

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү баримт бичгээр Монголын цахилгаан холбоо ХК-ийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогыг тодорхойлно.

1.2. Бодлогын баримт бичгийн зорилго нь МЦХ ХК-ийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, техник, технологийн тасралтгүй ажиллагааг хангахтай холбогдуулан удирдах албан тушаалтнууд гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн хувьцаа эзэмшигч, хэрэглэгч, хамтран ажиллаж буй бусад этгээдүүд хохирохгүй байх нөхцөлийг хангахад оршино.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид "Хороо" гэх/ нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой санал, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулж батлуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаар Гүйцэтгэх захирал зөвлөмж өгөх, бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулна.

2.3. Хороо нь МЦХ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлж санал дүгнэлт гаргана.

2.4. Хороо нь гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнд нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлагатай холбоотой асуудлаар Гүйцэтгэх захиралтай зөвшилцөх, зөвлөмж өгөх эрхтэй.

2.5. Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргаж болно.

2.6. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс өндөр насны тэтгэвэрт гарах, таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх захирал жил бүр судалгаа хийнэ.

ГУРАВ. БУСАД

3.1. Энэ баримт бичгийн хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулна.